



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 2/44

Улаанбаатар хот

Ахмадуудыг хүлээн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон Улсын ахмад настны эрхийг хамгаалах өдөр, Монголын ахмадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын хороонд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг 2018 оны 10 дугаар сарын 02 -ны өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Байгууллагын ахмадуудыг хүлээн авч, хүндэт үзүүлэхэд шаардагдах 290.000 /хоёр зуун ерэн мянга/ төгрөгийн тэтгэмжийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.


3. Ахмадуудыг хүлээн авах бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллахыг мэргэжилтэн /М.Цогзолмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын
хорооны даргын 2018 оны .09.27-ны сарын
28-ны өдрийн 44 дугаар тушаалын хавсралт



Ахмадуудаа хүлээн авах төсөв

№	Зардлын нэр	Дүн
1.	Ахмадууд /4 хүн x 72.500/	290.000 төг
	Дүн	290.000 төг